



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2024/12-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtuyach@audit.gov.mn">Enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a>
2024 он	Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-3047 Цахим хаяг: <a href="mailto:Narantsetsegba@audit.gov.mn">Narantsetsegba@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14-15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15-16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16-17
4. Аудитын тайлан	18-20
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18-19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	20-23
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24-25

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайд
ХШҮДАГ	Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА  
Б.МӨНХТӨР ТАНАА

2024.02.23 № САА-2024/12-НА-СТА-743  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд ХХААХҮЯ-аас “Экспортыг дэмжих” төслийн хүрээнд дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн нийт 184,997.0 мянган төгрөгийн өртөг бүхий агуулахын материал, өргөгч тоног төхөөрөмж, “Жимс жимсгэнийн хүлэмжийн загвар аж ахуй байгуулах” төслийн хүрээнд Шаамар суманд байгуулагдсан нийт 397,494.3 мянган төгрөгийн өртөгтэй ажлын байр, худаг, услалтын систем, хамгаалалтын хашаа болон 30 ширхэг хүлэмжийг тус тус хүлээлгэн өгсөн байна.

**Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагч буюу ХХААХҮЯ-аас өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор тайлант оны 12 дугаар сард тээвэр, шатахууны зардалд

төсвийн зохицуулалт хийсний улмаас жилийн эцэст **15,136.6** мянган төгрөгийн түлш, шатахуун нөөцөлсөн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь тайлант оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 33 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 87.2 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,275,948.37</b>	<b>209,960,605.55</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>26,118,494.39</b>	<b>39,440,331.57</b>
<b>33300</b>	<b>Татаас санхүүжилтийн авлага</b>	<b>0.00</b>	<b>1,027,970.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>26,118,494.39</b>	<b>38,412,361.57</b>
33510	Байгууллагаас авах авлага	26,118,494.39	24,722,472.56
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	13,689,889.01
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>10,157,453.98</b>	<b>170,520,273.98</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>6,764,553.98</b>	<b>6,764,553.98</b>
35110	Тусгай зориулалттай материал	6,764,553.98	6,764,553.98
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>3,392,900.00</b>	<b>163,755,720.00</b>
35410	Бичиг хэргийн материал	126,000.00	2,858,680.00
35420	Аж ахуйн материал	546,000.00	931,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	15,136,640.00
35470	Бусад хангамжийн материал	2,720,900.00	144,829,400.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>241,058,839.57</b>	<b>588,989,064.01</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>241,058,839.57</b>	<b>588,989,064.01</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>235,774,172.89</b>	<b>584,021,064.01</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	116,789,480.96	198,695,396.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,387,306.24	-31,372,937.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	173,150,000.00	176,650,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-150,833,333.44	-159,616,666.78
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	172,967,572.76	263,908,480.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-112,323,338.92	-160,183,037.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,881,976.75	28,836,333.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,851,305.01	-23,508,530.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	108,805,609.93	399,393,990.09
39215	Хуримтлагдсан элэгдэл	-57,425,183.90	-108,781,964.96
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,284,666.68</b>	<b>4,968,000.00</b>
39301	Программ хангамж	6,800,000.00	6,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,483,333.32	-6,800,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,968,000.00	4,968,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>277,334,787.94</b>	<b>798,949,699.56</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>17,765,584.39</b>	<b>15,691,582.39</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>17,765,584.39</b>	<b>15,691,582.39</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>17,765,584.39</b>	<b>15,691,582.39</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,074,002.00	0.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>15,691,582.39</b>	<b>15,691,582.39</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	15,691,582.39	15,691,582.39
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>259,569,203.55</b>	<b>783,258,087.17</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>259,569,203.55</b>	<b>783,258,087.17</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	806,717,089.41	806,717,089.41
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	806,717,089.41	806,717,089.41
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-632,574,454.14</b>	<b>-108,885,570.52</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-546,027,474.29	-632,574,454.14
51220	Тайлант үеийн үр дүн	-86,546,979.85	523,688,883.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,426,568.28	85,426,568.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>277,334,787.94</b>	<b>798,949,669.56</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>885,486,865.25</b>	<b>1,875,773,645.35</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>215,113,665.25</b>	<b>1,105,160,535.35</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>215,113,665.25</b>	<b>1,105,160,535.35</b>	
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>210,000.00</b>	<b>0.00</b>	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	0.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	16,274,400.00	456,069,365.35	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	198,629,265.25	649,091,170.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>670,373,200.00</b>	<b>770,613,110.00</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>652,772,500.00</b>	<b>715,742,400.00</b>	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	652,772,500.00	715,742,400.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>17,600,700.00</b>	<b>54,870,710.00</b>	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,300,700.00	51,955,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,300,000.00	2,915,310.00	
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>835,614,125.10</b>	<b>945,870,625.73</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>835,614,125.10</b>	<b>945,870,625.73</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>786,908,321.87</b>	<b>847,724,533.90</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>237,507,174.36</b>	<b>471,408,081.42</b>	
210101	Үндсэн цалин	177,033,509.73	307,092,506.31	
210102	Нэмэгдэл	36,299,831.63	115,637,711.64	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,177,000.00	9,873,911.45	
210104	Урамшуулал	17,996,833.00	38,803,952.02	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,961,979.74</b>	<b>60,164,948.29</b>	
210201	Тэтгэврийн даатгал	21,176,300.12	41,381,800.00	
210202	Тэтгэмжийн даатгал	2,428,760.10	4,727,300.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,882,528.14	3,773,955.36	
210204	Ажилгүйдлийн даатгал	406,762.88	919,308.38	
210205	Эрүүл мэндийн даатгал	4,067,628.50	9,362,584.55	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,066,201.61</b>	<b>18,334,299.89</b>	
210301	Гэрэл, цахилгаан	1,445,216.61	1,667,493.89	
210302	Түлш, халаалт	14,969,065.00	14,969,066.00	
210303	Цэвэр, бохир ус	1,651,920.00	1,697,740.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,365,706.06</b>	<b>44,869,541.39</b>	
210401	Бичиг хэрэг	1,427,750.00	4,279,320.00	
210402	Тээвэр, шатахуун	18,418,587.00	28,920,250.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,884,569.06	2,218,321.39	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,634,800.00	9,451,650.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0</b>	<b>20,000,000.00</b>	
210604	Урсгал засвар	0	20,000,000.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,894,500.00</b>	<b>32,025,600.00</b>	
210702	Дотоод албан томилолт	7,894,500.00	32,025,600.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>321,850,355.00</b>	<b>50,480,172.00</b>	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	308,498,550.00	42,241,600.00	

210803	Даатгалын үйлчилгээ	5,165,005.00	2,955,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	272,100.00	272,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	120,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,740,000.00	4,740,000.00
210807	Газрын төлбөр	53,700.00	150,172.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>146,262,405.10</b>	<b>150,441,890.91</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,671,450.00	17,843,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	23,634,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,590,955.10	108,964,140.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,705,803.23</b>	<b>98,146,091.83</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,755,200.00</b>	<b>500,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,355,200.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,950,603.23</b>	<b>97,646,091.83</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,272,613.23	8,049,175.01
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	23,677,990.00	89,596,916.82
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>49,872,740.15</b>	<b>929,903,019.62</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>136,419,720.00</b>	<b>406,214,136.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	136,419,720.00	406,214,136.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-86,546,979.85</b>	<b>523,688,883.62</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>694,261,190.00</b>	<b>859,872,776.82</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>210,000.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>210,000.00</b>	<b>0.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>210,000.00</b>	<b>0.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>694,051,190.00</b>	<b>859,872,776.82</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>652,772,500.00</b>	<b>715,742,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	652,772,500.00	715,742,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>41,278,690.00</b>	<b>144,130,376.82</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,300,700.00	51,955,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,300,000.00	2,915,310.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,677,990.00	89,259,666.82
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>694,261,218.00</b>	<b>859,047,776.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>694,261,218.00</b>	<b>859,047,776.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>645,555,414.77</b>	<b>759,873,714.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>237,592,974.36</b>	<b>471,408,081.42</b>
210101	Үндсэн цалин	177,033,509.73	307,092,506.31
210102	Нэмэгдэл	36,299,831.63	115,637,711.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,262,800.00	9,873,911.45
210104	Урамшуулал	17,996,833.00	38,803,952.02
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,961,979.74</b>	<b>60,164,948.29</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,176,300.12	41,381,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,428,760.10	4,727,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,882,528.14	3,773,955.36
210204	Ажилгүйдлийн даатгал	406,762.88	919,308.38
210205	Эрүүл мэндийн даатгал	4,067,628.50	9,362,584.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,906,399.61</b>	<b>20,408,301.89</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,445,216.61	1,667,493.89
210302	Түлш, халаалт	12,895,063.00	17,043,068.00
210303	Цэвэр, бохир ус	1,566,120.00	1,697,740.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,931,606.06</b>	<b>61,243,861.39</b>
210401	Бичиг хэрэг	1,732,750.00	5,273,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,418,587.00	42,776,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,884,569.06	2,218,321.39
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,895,700.00	10,975,650.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>115,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	115,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>307,000.00</b>	<b>20,000,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	307,000.00	0
210604	Урсгал засвар	0	20,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,894,500.00</b>	<b>32,025,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,894,500.00	32,025,600.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>314,650,355.00</b>	<b>53,030,172.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	308,498,550.00	44,791,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,165,005.00	2,955,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	272,100.00	272,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	120,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	4,740,000.00
210807	Газрын төлбөр	53,700.00	150,172.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,310,600.00</b>	<b>41,477,750.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,310,600.00	17,843,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	23,634,750.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,705,803.23</b>	<b>99,174,061.83</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,755,200.00</b>	<b>500,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,355,200.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,950,603.23</b>	<b>98,674,061.83</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,272,613.23	8,049,175.01
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	23,677,990.00	90,624,886.82
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>-28</b>	<b>825,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>825,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>825,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>825,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	825,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>0.00</b>	<b>-825,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-28</b>	<b>0.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	-546,027,474.29	346,116,183.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	-546,027,474.29	346,116,183.40
4	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
5	Тайлант үеийн үр дүн	0	0	-86,546,979.85	-86,546,979.85
6	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	-632,574,454.14	259,569,203.55
7	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	-632,574,454.14	259,569,203.55
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
10	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
11	Тайлант үеийн үр дүн	0	0	523,688,883.62	523,688,883.62
12	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	-108,885,570.52	783,258,087.17

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>715,742,400.00</b>	<b>708,091,224.99</b>	<b>7,651,175.01</b>	<b>98.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>715,742,400.00</b>	<b>708,091,224.99</b>	<b>7,651,175.01</b>	<b>98.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>715,167,600.00</b>	<b>707,591,224.99</b>	<b>7,576,375.01</b>	<b>98.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>471,528,400.00</b>	<b>471,408,081.42</b>	<b>120,318.58</b>	<b>99.9</b>
210101	Үндсэн цалин	312,474,900.00	307,092,506.31	5,382,393.69	98.3
210102	Нэмэгдэл	128,075,200.00	115,637,711.64	12,437,488.36	90.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,323,000.00	9,873,911.45	4,449,088.55	68.9
210104	Урамшуулал	16,655,300.00	38,803,952.02	-22,148,652.02	232.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,292,000.00</b>	<b>60,164,948.29</b>	<b>127,051.71</b>	<b>99.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,381,800.00	41,381,800.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,727,300.00	4,727,300.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,782,200.00	3,773,955.36	8,244.64	99.8
210204	Ажилгүйдлийн даатгал	945,800.00	919,308.38	26,491.62	97.7
210205	Эрүүл мэндийн даатгал	9,454,900.00	9,362,584.55	92,315.45	99.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,112,100.00</b>	<b>20,408,301.89</b>	<b>1,703,798.11</b>	<b>92.3</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,330,100.00	1,667,493.89	1,662,606.11	50.1
210302	Түлш, халаалт	17,070,900.00	17,043,068.00	27,832.00	99.8
210303	Цэвэр, бохир ус	1,711,100.00	1,697,740.00	13,360.00	99.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>51,712,300.00</b>	<b>50,331,321.39</b>	<b>1,380,978.61</b>	<b>97.3</b>
210401	Бичиг хэрэг	5,286,600.00	5,273,000.00	13,600.00	99.7
210402	Тээвэр, шатахуун	38,068,100.00	37,997,250.00	70,850.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,237,600.00	2,218,321.39	19,278.61	99.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,120,000.00	4,842,750.00	1,277,250.00	79.1
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>115,300.00</b>	<b>115,000.00</b>	<b>300.00</b>	<b>99.7</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	115,300.00	115,000.00	300.00	99.7
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,980,000.00</b>	<b>20,825,000.00</b>	<b>155,000.00</b>	<b>99.3</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	980,000.00	825,000.00	155,000.00	84.2
210604	Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>33,379,200.00</b>	<b>31,308,400.00</b>	<b>2,070,800.00</b>	<b>93.8</b>
210702	Дотоод албан томилолт	33,379,200.00	31,308,400.00	2,070,800.00	93.8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>54,576,500.00</b>	<b>53,030,172.00</b>	<b>1,546,328.00</b>	<b>97.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,071,900.00	44,791,600.00	1,280,300.00	97.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	205,900.00	0	205,900.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,955,700.00	2,955,700.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	272,000.00	272,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,700.00	120,700.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,800,000.00	4,740,000.00	60,000.00	98.8

210807	Газрын төлбөр	150,300.00	150,172.00	128.00	99.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>471,800.00</b>	<b>0</b>	<b>471,800.00</b>	<b>0.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	471,800.00	0	471,800.00	0.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>574,800.00</b>	<b>500,000.00</b>	<b>74,800.00</b>	<b>87.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>574,800.00</b>	<b>500,000.00</b>	<b>74,800.00</b>	<b>87.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	574,800.00	500,000.00	74,800.00	87.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>715,742,400.00</b>	<b>715,742,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>715,742,400.00</b>	<b>715,742,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	715,742,400.00	715,742,400.00	0.00	100.0
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>27</b>	<b>27</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>144,130,376.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>144,130,376.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>53,107,490.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,912,540.00</b>
210402	Тээвэр, шатахуун	4,779,640.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,132,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>717,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	717,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>41,477,750.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,843,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,634,750.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>91,022,886.92</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>91,022,886.92</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	398,000.00
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэг шилжүүлэг	90,624,886.82
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>144,130,376.82</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>144,130,376.82</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,955,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,915,310.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	89,259,666.82

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /цаашид Хүнс, хөдөө аж ахуйн газар гэх/ нь “Хүнс, газар тариалан, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийн инновацыг нэвтрүүлэх, үйлдвэрлэлийг түүхий эдээр, хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангаж, эдийн засгийн үр ашигтай, өрсөлдөх чадвартай, байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд чиглэгдэнэ” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дугаар сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлөгдөх, хяналт тавих журам”-д 2023 оны 10 дугаар сарын 04-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаанд ХХААХҮС-ын дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөний дагуу ХШҮДАГ-аас хяналт шалгалт хийгдэж, анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой 1 албан шаардлага, үндсэн хөрөнгө, шилэн данстай холбоотой 5 зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/359 дүгээр тушаалаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 521,614.9 мянган төгрөгөөр буюу 2.9 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	26,118.5	39,440.3	13,321.8
Бараа материал	10,157.5	170,520.3	160,362.8
Үндсэн хөрөнгө	241,058.8	588,989.1	347,930.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>277,334.8</b>	<b>798,949.7</b>	<b>521,614.9</b>
Өр төлбөр	17,765.6	15,691.6	(2,074.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	259,569.20	783,258.1	523,688.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>277,334.8</b>	<b>798,949.7</b>	<b>521,614.9</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.  
Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 13,321.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ХХААХҮЯ-аас аж ахуйн нэгж, иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон хүнсний ногооны үрийн төлбөр төлөгдөөгүйгээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 160,362.8 мянган төгрөгөөр өссөн нь ХХААХҮЯ-аас 138,577.0 мянган төгрөгийн ногооны агуулахын

хайрцгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 15,136.6 мянган төгрөгийн шатахуун худалдан авч, үлдэгдлээр тайлагнасан,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 347,930.3 мянган төгрөгөөр өссөн нь ХХААХҮЯ-аас нийт 443,894.3 мянган төгрөгийн, аймгийн ИТХ-ын тогтоолоор МХГ-аас 20,670.3 мянган төгрөгийн, ТӨБЗГ-аас 3,500.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авснаас голлон шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг **516,055.3** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 41,986.7 мянган төгрөгөөр бууруулж, **474,068.6** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 50,000.0 мянган төгрөгөөр,
- Цалин хөлс болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 84,873.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол
- Газар тариалан хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 42,600.0 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 31,232.4 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 59,095.0 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 36,746.2 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд батлагдсан төсвийг нийт 241,673.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **715,742.4** мянган төгрөг болгон төсвийн зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- 7 дугаар сараас албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 144,013.2 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой зардлыг 9,674.0 мянган төгрөгөөр,
- Хангамжийн материалын зардлыг 36,700.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 20,825.0 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 15,700.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлыг 7,657.5 мянган төгрөгөөр,
- Мэргэжлийн хяналтын хөтөлбөрийн зардлыг 26,773.1 мянган төгрөгөөр,
- Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 10,431.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 3,400.0 мянган төгрөгөөр,
- Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 39,569.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан зэрэг.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 715,742.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, санхүүжилтийг бүрэн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 708,091.3 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардал 7,576.3 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Мэргэжлийн хяналт	26,773.1	23,877.2	2,895.9	89.2
2	Мал аж ахуйг хөгжүүлэх	10,431.0	10,431.0	-	100
3	Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	23,300.0	23,121.8	178.2	99.2
4	Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, үндсэн үйл ажиллагаа	654,663.5	650,161.3	4,502.2	99.3
5	Ажил олгогчоос олгох тэтгэмж	574.8	500.0	74.8	87.0
	<b>Дүн</b>	<b>715,742.4</b>	<b>708,091.3</b>	<b>7,651.1</b>	<b>98.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130019401 тоот дансанд нийт 144,130.4 мянган төгрөгийн дараах орлогуудыг төвлөрүүлж, 53,107.5 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, хүнсний ногооны үрийн болон төсвийн хэмнэлтийн нийт 91,022.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлжээ. Үүнд:

- Иргэд, аж ахуйн нэгжээс хөнгөлөлттэй үнээр олгосон эргэн төлөгдөх хүнсний ногооны үрийн авлагын 89,259.7 мянган төгрөгийг,
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн газраас зээл авсан аж ахуйн нэгж болон иргэдийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэхэд зориулан шатахуун, албан томилолтын зардалд 1,887.3 мянган төгрөгийг,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс үржлийн малд үзлэг ангилалт хийж, цөм сүрэг бүрдүүлэхэд зориулан 3,440.0 мянган төгрөгийг, төмс хүнсний ногоо, зөгийн аж ахуй, махны үхрийн аж ахуй эрхлэгчид болон малчид, тариаланчдын уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулахад зориулан 48,515.4 мянган төгрөгийг,
- ХХААХҮЯ-наас бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад зориулан хяналтаар ажиллах шатахууны 1,027.9 мянган төгрөгийг олгосон бөгөөд уг ажил хийгдээгүйгээс татан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 835,614.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **8,356.1** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны төсөв материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 945,870.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **9,458.7** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг хэмнэсэн,
- Цэвэрлэгээ, дотоод хэрэгцээний зардлыг хэмнэснээр хангамжийн материалын 1,380.9 мянган төгрөгийн,

- Байгууллагын дулаан, цахилгааны хэрэглээнд хэмнэлтийн горим хэрэгжүүлж, 1,703.8 мянган төгрөгийн төсвийг тус тус хэмнэсэн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хүнс, хөдөө аж ахуйн газар нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 159 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар албан хаагчдыг албан томилолтоор ажилласан үеийн унаа хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон зөрчлийг арилгаж, 12 дугаар сарын цалингаас суутган тооцууллаа.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 450.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,207.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 344.6 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 83.3 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	450.0	1	450.0	100
Албан шаардлага	1	4,207.8	1	4,207.8	100
Зөвлөмж	4	344.6	3	344.6	75

Нийт дүн	6	5,002.4	5	5,002.4	83.3
----------	---	---------	---	---------	------

Өмнөх онд өгөгдсөн ХХААХҮЯ болон ХААДС-аас аж ахуйн нэгж, иргэдэд хөнгөлөлттэй үнээр олгосон хүнсний ногооны үрийн авлагыг барагдуулах үр дүн бүхий арга хэмжээ аваагүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны төсвийн захирагч буюу ХХААХҮЯ-аас өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор тайлант оны 12 дугаар сард тээвэр, шатахууны зардалд төсвийн зохицуулалт хийж, жилийн эцэст **15,136.6** мянган төгрөгийн шатахуун нөөцөлсөн байна. Дараагийн аудитаар уг шатахууны үлдэгдлийн зарцуулалтыг тулгах.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **32,707.8** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс **1,187.9** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **7,736.2** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **23,783.7** мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тус газрын дарга Б.Мөнхтөрд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг зөрүүтэй тооцоолж, нийт **1,187.9** мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.” гэж заасныг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн Б/26 дугаар тушаалын дагуу 1,2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгохдоо тухайн үеийн бус 7 дугаар сарын үндсэн цалингаас тооцож 534.7 мянган төгрөг илүү,
- 2022 оны 04 дүгээр улирлын үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн урамшууллыг 100.0 хувиар тооцож, 653.2 мянган төгрөг илүү гэх мэт.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

5.2.1. Дээд шатны төсвийн захирагч буюу ХХААХҮС-ын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/18 дугаар тушаалын 16 дугаар хавсралтаар баталсан архив, бичиг хэрэг-нярвын орон тооноос нярвын үүрэгт ажлыг салгаж, жолооч П.Сугараар хавсран гүйцэтгүүлэн, хавсран ажилласны нэмэгдэлд нийт **2,799.6** мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.3-д *“Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баталсан орон тоог мөрдөн, цалин хөлсийг олгож байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 1 аж ахуйн нэгж, 8 иргэнд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон **4,512.9** мянган төгрөгийн хүнсний ногооны үрийн төлбөрийг гэрээт хугацаанд барагдуулаагүй байна.

Энэ нь Хүнсний ногооны үр худалдах, худалдан авах гэрээний 2 дугаар зүйлийн 2.4-т *“Худалдан авагч нь хүнсний ногооны үрийг урьдчилгаагүй авч, үлдэгдэл 100 хувийн төлбөрийг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор төлнө”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон ногооны үрийг гэрээт хугацаанд барагдуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.3. Албан хаагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн төрлийг цалингийн программд буруу сонгосноос 1 албан хаагчаас суутгах суутгалыг **180.1** мянган төгрөгөөр дутуу ногдуулж, албан татварын өр төлбөр, 2 албан хаагчаас суутгах шимтгэлийг илүү ногдуулж, **243.6** мянган төгрөгийн цалингийн өр төлбөр тус тус үүсгэсэн боловч бүртгэл тайланд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 20 дугаар зүйлийн 20.2-т *“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулсны үндсэн дээр ажил, гүйлгээг гүйцэтгэх, төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **5.3.1 Анхан шатны баримттай холбоотой асуудал**

5.3.1.1. Илрүүлэлт: Гэрээ, хүлээлгэн өгсөн баримт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 4 иргэнд нийт **8,430.0** мянган төгрөгийн хүнсний ногооны үр олгож, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх 4 иргэнд олгосон ногооны үрийг анхан шатны баримтаар нөхөн баталгаажуулж, авлагыг барагдуулах.

5.3.1.2 Илрүүлэлт: Авто машины эвдрэл, гэмтэл, засварын төсөв, тооцоо судалгааг Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж, тодорхойлолгүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд нийт **15,000.0** мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Авто машины эвдрэл гэмтлийг Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж, тодорхойлох, төсөв, тооцоо судалгаа зэрэг анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

#### **5.3.2 НДШ, ХХОАТ-ын тайлагналтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын болон ХХОАТ-ын тайланд мэргэжилтэн Б.Баярзулын **353.7** мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: 2024 оны 2 дугаар улиралд багтаан залруулгыг хийж, нийгмийн даатгал болон татварын тайланд үнэн зөв тусгах.

#### **5.3.3 Газрын эзэмшил, бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Төрийн мэдээлэл солилцооны хур системд тухайн байгууллагын эзэмшилд 4 газар бүртгэлтэй байгаа боловч санхүүгийн тайланд зөвхөн конторын барилгын газар бүртгэгдэж, Ерөө болон Сүхбаатар суманд байршилтай ногооны

зоорь, ногооны тариалангийн зориулалттай газрууд бүртгэгдэж, тайлагнагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”: 14.4.2-д “бүх хөрөнгө, ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх газруудын эзэмших эрхийн асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлэх, бүртгэл тайланд тусгах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/									
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөр-ийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн мөнгөн урамшуулал илүү тооцож олгосон.	1	1,187.9	1	1,187.9								
Төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	2,799.6			1	2,799.6						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан.	1	4,512.9			1	4,512.9						
Өр төлбөр үүсгэсэн, бүртгэл тайланд тусгаагүй.	1	423.7			1	423.7						
Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэсэн.	2	23,430.0					2	23,430.0				
НДШ, Татварын тайланд цалин дутуу илэрхийлсэн.	1	353.4					1	353.7				
Газрыг санхүүгийн тайланд тусгаагүй.	1						1					
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>32,707.8</b>	<b>1</b>	<b>1,187.9</b>	<b>3</b>	<b>7,736.2</b>	<b>4</b>	<b>23,783.7</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								